



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/158

Мандалговь

“Миний хүлэг” ХХК-тай гэрээ
байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн А/158 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Дундговь аймгийн төвийн хог хаягдлыг бууруулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх”-ийн ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Миний хүлэг” ХХК-тай 48,589,250 (дөчин найман сая таван зуун наян есөн мянга хоёр зуун тавь) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг, төсвийн дагуу “Дундговь аймгийн төвийн хог хаягдлыг бууруулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх” ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Миний хүлэг” ХХК-ийн захирал (Ц.Тогтохбаяр)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Сайнцагаан сумын Засаг дарга, Мандалговь хотын захирагч (Р.Мөнхтогтох), Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (Н.Гантулга), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА Ц.ЭРДЭНЭСҮРЭН



482060766